


## БАЙЦАА

### Ач холбогдол.

	<p>Шингэц сайтай, С амин дэм ихээр агуулсан элэг, цөсний үйл ажиллагаанд сайнаар нөлөөлдөг учир элэгний шүүр гэж нэрлэх нь бий.</p>
---	---

**Сорт.** Байцааг эрт, дунд, орой болцтой гэж ангилна. Эрт болцтой сорт 75 хоногт, дунд болцтой нь 90 хоногт, орой болцтой нь 120-с дээш хоногт ургаж гүйцдэг. 1м.кв талбайгаас 5кг байцаа хураан авна.



**Ургах нөхцөл.** Үржил шим сайтай, хар хүрэн, шаварлаг хөрсөнд тарина. Үрслэг нь ургалтын үедээ 2-5 С°-ийн хүйтнийг тэсвэрлэж чаддаг. Байцаа нь хөрсний хүчиллэг ба шүлтлэгийг тэсвэрлэхдээ муу учир түүнийг тариалах хөрсний РН-ийн хэмжээ 6,5-7,0 байна.

**Хөрс боловсруулалт.** 1 м.кв талбайг 9-10 кг бүрэн ялзарсан бууцаар бордож 25-30см гүн хагалж боловсруулна.



**Тарилт:** Говийн нөхцөлд аль ч сортын байцааг тарихад ургалт нь гүйцэж ургац авах боломжтой боловч дунд ба оройн болцтой байцааг заавал үрслэгээр тарина. Харин эртийн байцааг шууд үрээр тарьж орой ургац авч болно.

**Үрслэг ургуулах.** Үрслэгийг 4-р сарын 1-10 –ны хооронд зориулалтын дарлаганд суулгана.


	<p>1. Дарлаганы нүхийг урд намар нь 60-80 см гүн ухаж бэлтгээд дараа хавар нь адууны хомоол ба хонины шар бууцаар 60-70см зузаан дүүргэж 1 м тутамд гал түлж халаана.</p>		<p>2. Дарлага доторхи бууцыг халах хооронд үрслэг ургуулах дэвсгэр хөрсийг бэлтгэнэ. Хөрс бэлтгэхэд шигшсэн хар шороо, элс, бууцыг 5:1:4 харьцаатайгаар холино.</p>
	<p>3. Бууц бүрэн халсаны дараа үрслэг ургуу-лахаар бэлтгэсэн хөрсийг 15-18 см зузаан хийж сайн нягтруулна.</p>		<p>4. Нягтруулсан хөрсний дулаан 15°С орчим болоход 60-80 хэмийн халуун усаар хөрсөө нэвчтэл услана</p>


	<p>5. Ус бүрэн нэвчсэний дараа хөрсөө тэгшлээд 5 см х 5 см дөрвөржлүүлэн зурж голд нь 1-1.5 см хонхойлж 2-3 ширхэг үр хийж элс ба хөрсөөр 1-1.5 см хучина</p>		<p>6. Үр соёолж гарч иртэл 3- хоног нийлэг хальсан хучлагыг авч болохгүй. Хэрэв хучлагыг авбал үр жигд соёолохгүй. Мөн дахин услах шаардлага гарна.</p>
	<p>7. Үрийн соёо жигд гарах үеэс өдөрт нь хучлага жаазыг авч шөнөд нь бүтээж гэрэл дулааныг тохируулана</p>		<p>8. 45-50 хоногийн дараа үрслэгийг ил талбайд гаргана. Зөв ургасан үрслэг тод ногоон өнгийн 4-6 навчтай, бахим бүдүүвтэр иштэй цөгц хэлбэртэй байна.</p>

### Тарилт

	<p>Байцаа нь навчны гадаргуу ихтэй ургамал учир түүний сортоос хамааран ургамал хооронд нь 40-60 см, мөр хооронд 50-70см зайтай тариалдаг. Жишээлбэл: эрт ургацын байцааг 40х50 см – ээр, Дунд болцтой байцааг 50х60см-ээр, орой болцтой байцааг 60х70-см-ээр тус тус тариалдаг. Үрслэгийг анхны навч хүртэл нь суулгана.</p>
	<p>Үрслэгийг ил талбайд суулгахын урьд өдөр маш сайн нэвтэртэл услаад оройн сэрүүн ба шиврээ бороотой үед ил талбайд шилжүүлнэ. Хэрвээ халуун наранд ил талбайд гаргавал сэргэн ургахдаа удаан байхаас гадна үхэлт ихтэй байна. Шилжүүлсэний дараа үрслэг бүрийг 2-3 литр усаар услана.</p>

### Арчилгаа

	<p>Үрслэгийг суулгасанаас хойш 3 хоноод 2-3 литр усаар, цаашид хөрс цаг уурын байдлаас шалтгаалан 10-14 хоног тутамд 3-4 литр усаар услана. Ургалт эрчимжсэнэс хойш 1-2 удаа гумины бордоо ба шингэрүүлсэн бууцаар бордож болно. Бордохдоо 100 литр усанд 20 г /4 цайны халбага/ гумины бордоо эсвэл 20кг бууц хийж уусгаад түүнийгээ 10 дахин шингэлж бордоод шууд услана.</p>
---	---



Усалгаа бүрийн дараа хөрсний өнгөн үеийг 6-8 см гүн сийрүүлж зэрлэг ургамлыг устгах, өндөрсөн ишийг манах ажлыг тогтмол хийнэ. Энэ нь хөрсний агааржилтыг сайжруулахаас гадна булагдсан ишнээс нэмэлт үндэс үүсэж ургамал хөрснөөс шим тэжээлийн бодис авах боломжийг сайжруулна. Ингэснээр ургалт эрчимжиж өндөр ургац авна.

### Ээлжлэн тариалалт.



### Хортонтой тэмцэх.

Хортонтой тэмцэх арга		Авах арга хэмжээ
Урьдчилан сэргийлэх ба дайжуулах		1.Тариалалт хийсэн өдрөөс эхлэн 3 хоног тутамд аргалын үнс пургиулна. 2.Сармис зэрэг үнэрт бодисууд талбайдаа байрлуулна. 3.Хилэн цэцэг, гоньд, лууван зэрэг үнэрт тарималуудыг байцааны талбайд зэрэгцүүлэн тариална.
Устгах арга	Химийн	Хлорфос, Карбофос, Сумицидин зэрэг хорыг 1л усанд 3 гр-аар найруулж 100 ml талбайд тоосруулан шүршинэ.
	Механик	Түүж устгана. Өглөөгүүр хүйтэн усаар услаж хортонг бээрүүлж унагана.
	Биологийн	Ургалт жигдэрсэн үед тахиа мэтийн хортонг түүж иддэг амьтадыг талбайд оруулна.

### Хадгалах.

Зоорилж, даршилж давсалж хадгалж болно. Зоорилж хадгалбал 0 °C-- +1 °C хэмийн температуртай 90-95%-агаарын харьцангуй чийгтэй нөхцөлд хамгаалалтын 2-3 давхар навчтайгаар тавиур сараалж дээр ишийг доош харуулж 0,70-1м өргөн, 0,6-0,7м өндөртэйгээр өрж хадгална. .